



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/157

Ховд

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21, 22 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дүрмийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумдад залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг байгуулж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, "Залуучуудын хөгжлийг дэмжих" аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөлийн гишүүд, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, улирал бүр тайланг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Баяртуяа)-д үүрэг болгосугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл байгуулах тухай аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/700 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0784
Zah A/157 Kh

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 23-ны өдрийн
А/157 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай.

Тэргүүн - Аймгийн Засаг дарга

Дэд тэргүүн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
- Жаргалант сумын Засаг даргын Нийгмийн бодлого хариуцсан орлогч
- Ховд Их Сургуулийн захирал
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийн тэргүүн
- Аймгийн Залуучуудын холбооны тэргүүн
- Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын холбоо
- Залуу багш нарын холбооны тэргүүн

-оОо-